



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/306

Улаанбаатар хот

Ариутгал халдваргүйжүүлэлтийн хяналтын цэгийг татан буулгах талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.4, 4.5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Онцгой комиссоос Баянзүрхийн товчооны ариутгал халдваргүйжүүлэлтийн хяналтын цэгийг татан буулгах шийдвэр гарсантай холбогдуулан тус хяналтын цэгийг 2017 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс татан буулгахыг Онцгой байдлын хэлтэс /В.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын хэлтэс /Д.Цэнд-Очир/, Цагдаагийн 3 дугаар хэлтэс /Ц.Ариунбат/, Замын цагдаагийн хэлтэс /Г.Мөнхжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

2.Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын дүн мэдээг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэст ирүүлэхийг Мал эмнэлэг үйлчилгээний алба Баяндэмбэрэл ХХК /Д.Цэндбаатар/-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч /Т.Батцогт/-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн А/306 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ